

## МОНГОЛ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ШИНЖИХ НЬ

*Б. Үрцэцэг\**

XX зууны 80-аад оны дунд үеэс нааш, дэлхий дахины эдийн засгийн даяаршил, зах зээлийн чиг хандлагыг дагалдан, урьд өмнө төлөвлөгөөт эдийн засгийн механизмыг хэрэгжүүлж ирсэн орнууд дараа дараалан, шинэчлэлийн өөр өөр арга замаар, зах зээлийн эдийн засагт шилжиж, энэ нь эдүгээ цагийн дэлхий ертөнцийн гол хандлага болж байна. Дэлхийн хүн амын бараг гуравны нэгийг эзэлдэг шилжилтийн улс орнуудын эдийн засгийн шилжилт, хөгжлийн асуудал XXI зууны дэлхийн эдийн засгийн хөгжилд чухал байр суурь эзлэх болж байгаа нь ч өнөө үеийн дотоод гадаадын эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд буй асуудлын нэг мөн. Нэн ялангуяа шилжилтийн үеийн улс орнуудын хэрэгжүүлж буй шинэтгэлийн хоёр өөр загвар, түүний үр ашиг, хор холбогдол, нөлөө зэрэг асуудал нэгэнт дотоод гадаадын эдийн засгийн салбарын судлаачдын гүнзгийрүүлэн шинжлэн судлах салбар болоод байна. Тийнхүү дэлхийн эдийн засгийн янз бүрийн тогтолцооны өвөрмөц онцлог, үр ашгийг судалдаг шинжлэх ухааны шинэ салбар - харьцуулсан эдийн засаг судлалын шинжлэх ухааны судалгааны арга маяг болон судлагдахууны орон байр өөрчлөгдөн, уламжлалт “измын” харьцуулах аргаас татгалзан, олон ургальч байдал шинээр буй болов. Түүнчлэн улам олон эрдэмтэн судлаач шилжилтийн орнуудын эдийн засгийг судалдаг шинээр хөгжиж буй шилжилтийн эдийн засаг судлалд анхаарлаа хандуулж байна.

Монгол Улс бол дорнод Европ маягийн эрс шинэтгэлийн загварыг хэрэгжүүлж буй Азийн орон юм. Монголын туршлага сургамж, улсынхаа онцлогт тулгуурлан сонгож авсан зах зээлийн эдийн засгийн хөгжлийн өвөрмөц загвар нь өнөөгийн шилжилтийн үедээ яваа улс орнуудад сургамж болохуйц ихээхэн үнэ цэнэтэй юм. Түүнчлэн шилжилтийн орнуудад тулгарч буй онол болон практикийн олон асуудлыг шийдвэрлэх, хамаарал бүхий шинжлэх ухааны салбар болон судалгааны хүрээний хөгжлийг урагшлуулахад ч ихээхэн ач холбогдолтой болно.

### **1. Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны зорьж буй загвар болон язгуур онцлог**

Нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц түүхэн байдал болон 70 шахам жилийн социалист хөгжлийн түүх бүхий Монгол Улс өнгөрсөн зууны 90-ээд оны эхээр олон улсын болон дотоодын өвөрмөц байдлын хүчин зүйлийн нөлөөгөөр, эрс шинэчлэлийн загварыг сонгон авч, өөрийн

\*Б. Үрцэцэг - Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор

өвөрмөц арга маягаар төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явцыг эхэлсэн билээ.

Монгол Улс шилжилтийн үеийн тогтолцоо болон эдийн засгийн бодлогыг сонгоход “Улс төрийн тогтолцоог үндсээр нь шинэчлэх” өөрөөр хэлбэл, “Үндсэн хуулийн засаглалын шилжилт”-ийг урьдач нөхцөл болгодог дорнод Европ маягийн эрс шинэтгэлийн загвар эргэлт буцалтгүй чухал үүрэг гүйцэтгэж, тус улсын төрийн тогтолцоо, өмчлөлийн хэлбэр болон бодлогын орчинд олон бодит өөрчлөлт гарсан юм. Түүнчлэн Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны өмчлөлийн үндэс, зорьж буй хэв загвар зэрэг язгуур онцлог болон үндсэн агуулгыг тодорхойлсон юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс “Барууны маягийн ардчилсан тогтолцооны” дор “хувийн өмч улсын эдийн засагт голлох байр суурь эзлэсэн”, “Засгийн газрын макро зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоо”-г буй болгохыг зорьсон юм. Түүний үндсэн онцлог гэвэл, эдийн засгийн үйл ажиллагаа шууд буюу дам байдлаар бараа бүтээгдэхүүн, мөнгөний солилцооны зах зээлийн харилцаанд орших, зах зээлийн субъектын (компани, үйлдвэр) үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бие даалгах, зах зээлийн аж ахуйн үйл ажиллагааг аажмаар хуульчлах явдал зэрэг байв.

Монгол Улс дэлхийн хоёр дахь социалист орон байсан бөгөөд өнгөрсөн 70 жилийн социалист хөгжил нь Монголын эдийн засагт хөгжил цэцэглэл ч авчирч, бас уламжлалт төлөвлөгөөт эдийн засагт нийтлэг оршдог гэм согогийг ч дагуулсан билээ. XX зууны 80-аад оны эцэс, 90-ээд оны эхэн үеийн өөрчлөлтийг дагалдан, Монгол Улс бүх нийтийн өмчид үндэслэсэн уламжлалт төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны болон хөгжлийн загвараас татгалзаж, барууны маягийн парламентын ардчилсан засаглал болон хувийн өмчид үндэслэсэн эдийн засгийн тогтолцоонд “бүх талаар шилжих” эрс маягийн шинэчлэлийн загварыг сонгон авч, үйлдвэрлэлийн хэрэгслийг хувьчлах үйл явцыг эхлүүлсэн юм.

Улсын өмчийг хувьчилсан нь Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих эхний зорилт, гарц, бас Монголын шинэчлэлийн эхэн үед хэрэгжүүлсэн “муужруулах эмчилгээний” гол цөм агуулга нь байв. Хувьчлалын үйл явц нь Монголын эдийн засгийн тогтолцооны шилжилтийн томоохон үйл явдал байсны хувьд тухайн үеийн Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд асар их, гүн гүнзгий нөлөө үзүүлсэн болно. Энэ нь Монголын өмчлөлийн хэлбэрийг үндсээр нь өөрчилж, тус улс хувийн өмчид үндэслэсэн барууны маягийн “ардчилсан эрх зүйт эдийн засгийн тогтолцоонд” шилжих шийдвэрлэх алхам байв. Түүнчлэн Монголын зах зээлийн эдийн засгийн тогтолцоог буй болгож, хөдөлгөхөд зайлшгүй шаардлагатай дагалдах хүчин зүйлүүд үүсэн бүрэлдэв. Хувьчлалтай нэгэн зэрэг хийсэн үнийн шинэчлэл, үнийн

загварын өөрчлөлт, мөнгө, санхүү болон гадаад худалдааны тогтолцооны шинэчлэл зэрэг дагалт шинэчлэлийн үйл явцууд Монгол Улсын байгуулахаар зорьсон зах зээлийн эдийн засгийн загварын язгуур онцлог, үндсэн агуулгыг өөр өөр өнцгөөс илтгэн харуулсан юм. Тэр нь Монгол Улсын хийсэн сонголт урд өмнөхөөс огт өөр тогтолцооны хийгээд хөгжлийн загвар болохын илрэл байлаа.

Аливаа улсын түүхэн үүрэг зорилт нь тухайн орны эдийн засгийн тогтолцооны загварыг тодорхойлоход шууд нөлөөлдөг билээ. Социализмын үеийн Монгол Улс нь ХХ зууны 20-иод оны эхнээс, хуучин ЗХУ-ын дэмжлэгт түшиглэн, “капиталист бус хөгжлийн замаар” замнасан “социалист интеграцын” гишүүн орон байсны хувьд, ямар ч сонголтгүйгээр уламжлалт төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны загварыг хэрэгжүүлж ирсэн нь түүхэн зайлшгүй хэрэг байв. Харин хэдэн арван жилийн түүхэн хөгжлийн үйл явцыг туулсны эцэст, олон улсын болон дотоодын гэнэт үүссэн өвөрмөц нөхцөл байдалд, уламжлалт төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо оршин байсан бодит орчин үндсээрээ өөрчлөгдөн, Монгол Улс огт өөр улс төрийн байгуулал, эдийн засгийн тогтолцоонд бүх талаар шилжих түүхэн сонголт хийхэд хүрсэн билээ. Тийнхүү зах зээлийн эдийн засгийн тогтолцооны зорьж буй загвар, түүний язгуур онцлогийг тодорхойлсон юм.

## **2. Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн хэм хэмжээ болон зах зээлийн системийн бүтээн байгуулалт**

Эрс шинжтэй шинэчлэл нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ бас зах зээлийн эдийн засгийн шилжилтийн анхны үр шимийг хүртээсэн болно. Хувьчлал болон мөнгө, санхүү, үнийн шинэчлэл зэрэг макро удирдлагын тогтолцооны шинэчлэл хийснээр зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн хэм хэмжээ бүрэлдэн тогтсон байна. Орон нутгийн болон улсын зах зээлийн удирдлагын төвүүдээс бүрдсэн зах зээлийн удирдлагын шинэ тогтолцоо, хувиараа аж ахуй эрхлэгчид болон янз бүрийн компани хуулийн этгээд, засгийн газрын удирдлагын салбараас бүрдсэн зах зээлийн субъект, бараа бүтээгдэхүүний зах зээл, үйлдвэрлэлийн гол чухал зах зээлийн анхны дүр төрх бүрэлджээ. Тэгснээр зах зээлийн системийн субъект, объектын бүтэц болон зах зээлийн эдийн засгийн орчлын микро үндэс, макро орчныг аажмаар бүрдүүлэн боловсронгуй болгох, тус улсын байгалийн нөхцөл болон эдийн засгийн хөгжлийн онцлогт тохирсон зах зээлийн эдийн засгийн орчил хөдөлгөөний замд алхан орох үндэс суурь тавигдсан байна.

Аливаа улсын эдийн засгийн тогтолцоо болон хөгжлийн загварын өөрчлөлт шилжилт нь үр ашиг бүхий зах зээлийн бүрдлийг урьдал болгодогийг шилжилтийн орнуудын шинэчлэлийн туршлага нотолж

байна. Харин үр ашигтай зах зээлийн бүрдэл нь үйлдвэр аж ахуйн өмчлөлийн тогтолцоо, зах зээл хоёр харилцан зохицож буй эсэхээс хамаардаг. Тиймээс үйлдвэр аж ахуй эрхлэх механизмыг өөрчлөх, үйлдвэр аж ахуйн зах зээлийн субъектын байр суурийг тодорхойлох, үйлдвэр аж ахуйг зах зээлийн эдийн засгийн орчлын микро үндэс болгох явдал бол зах зээлийн эдийн засгийн үндсэн хэм хэмжээг бүрдүүлэх тэргүүн зэргийн зорилтын нэг мөн.

1991 онд Монгол Улсын Бага Хурал “Өмч хувьчлалын хуулийг” баталж, улсын өмчийг хувьчилснаар, Монгол Улсын үйлдвэр аж ахуйн өмчлөлийн тогтолцооны шинэчлэл эхэлсэн билээ. Хувьчлалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, олон улсын шаардлагад нийцсэн нийтлэг чиг хандлагын дагуу, хувьцааны системийг үйлдвэр аж ахуйн өмчлөлийн тогтолцооны шинэчлэлийн гол хэлбэр болгон, улсын том, дунд үйлдвэр аж ахуйн газарт хувьцааны системийг хэрэгжүүлсэн байна. Шинээр байгуулагдсан хувьцаат үйлдвэр аж ахуй газрууд хэдийгээр түүхий эд, техник тоног төхөөрөмж дутагдах зэрэг бодит шалтгааны улмаас төлөвлөсөн үр дүнд хүрээгүй боловч, зах зээлийн эдийн засгийн шаардлагад нийцсэн орчин үеийн үйлдвэрийн тогтолцоо болохын хувьд, Монгол Улс зах зээлийн эдийн засгийн системийн үндсэн хэм хэмжээг тогтооход чухал бүрэлдэхүүн хэсэг болсон нь дамжиггүй.

1991 оны 5-р сард, Монгол Улс “Өмч хувьчлалын хууль” батлахын сацуу, үйлдвэрийн газрын тухай хууль баталж, үйлдвэр аж ахуйн газар хэмээх ойлголтыг “тогтвортой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг, өөрийн бүх хөрөнгөөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон холбогдох хариуцлагыг хүлээдэг бие даасан нэгжийг үйлдвэр аж ахуйн газар гэнэ” гэж тодорхойлов. Монголын үйлдвэр аж ахуйн газар хэлбэрийн хувьд хувийн үйлдвэр, хамтарсан үйлдвэр, компани болон хуваагдаж, өмчийн хэлбэрээр нь улсын, хувийн, холимог хэлбэрийн гэж ангилах болжээ. Компанийг хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат гэж ангилжээ.

Үйлдвэрийн тухай хууль гарснаар Монголд үйлдвэрийн өмчлөлийн харилцааг тодорхойлон, үйлдвэр аж ахуйн механизмыг өөрчлөх болон зах зээлийн аж ахуйн үйл ажиллагааг хуульчлах эрх зүйн чухал үндэслэл буй болж, үйлдвэрийн газар нь бие даан үйлдвэрлэл явуулж, ашиг, алдагдлаа өөрөө хариуцан, өөрийгөө өөрөө хөгжүүлдэг хуулийн этгээд, зах зээлийн өрсөлдөөний субъект болж, Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн орчлын микро үндэс бүрдэх чухал нөхцөл болсон байна. Үүний зэрэгцээ, санхүү, банкны системийн шинэчлэл зэрэг макро удирдлагын тогтолцоог шинэчлэн, зах зээлийн эдийн засгийн хууль эрх зүйн тогтолцоог буй болгосноор засгийн газраас зах зээлийг зохицуулах макро зохицуулалтын систем аажмаар бүрэлдэн тогтсон ажээ.

Хууль эрх зүйн боловсронгуй системийг бүрдүүлэх нь зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн хэм хэмжээг тогтоох ажлын чухал хэсэг болно. Монгол Улсын одоогийн хууль эрх зүйн систем нь дараах хэд хэдэн үндсэн агуулгыг багтааж байна. Үүнд: 1. Засгийн газраас зах зээлд хэрэгжүүлж буй макро зохицуулалтын тухай хуулиуд, өөрөөр хэлбэл макро зохицуулалтын хууль, үүнд: төсвийн тухай хууль, банкны тухай хууль зэрэг багтана. 2. Зах зээлийн субъектын зохион байгуулалтын хэлбэр, хуулиар эзлэх байр суурийг тодорхойлсон хуулиуд, өөрөөр хэлбэл зах зээлийн субъектын хууль, үүнд: үйлдвэрийн газрын тухай хууль, дампуурлын хууль зэрэг багтана. 3. Зах зээлийн шударга өрсөлдөөнийг хамгаалахад чиглэсэн хуулиуд, өөрөөр хэлбэл зах зээлийн дэг журмын тухай хууль, үүнд: шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль зэрэг багтана. 4. Ажиллагсдад нийгмийн хамгаалал үзүүлэхэд чиглэсэн хуулиуд, өөрөөр хэлбэл нийгмийн хамгааллын хууль, үүнд: хөдөлмөрийн хууль, халамжийн хууль зэрэг багтана.

Дээр өгүүлсэн хууль эрх зүйн систем нь өөр өөр талаас нь Монголын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үндсэн хэм хэмжээг бүрдүүлж, зах зээлийн эдийн засгийн орчлын микро үндэс, макро орчин бүрэлдэн тогтох явдлыг нөхцөлдүүлж байна.

Монгол Улс урд өмнө нь урт хугацааны турш уламжлалт төлөвлөгөөт эдийн засгийн механизмыг хэрэгжүүлэн, зах зээлийн механизмын үүрэг нөлөөг үгүйсгэн шахаж ирсний улмаас, XX зууны 90-ээд оноос өмнөх Монгол Улсад зах зээлийн орчлын хэвийн механизм бүрэлдэн тогтоогүй байсан билээ. Шилжилтийн үед орсноос хойш улс төр, эдийн засгийн тогтолцооны шинэчлэлийг дагалдан Монгол Улсын зах зээлийн макро орчинд асар том, гүн гүнзгий өөрчлөлт гарч, шинэ зах зээлийн систем болон зах зээлийн орчлын механизм бүрдэхэд зайлшгүй шаардлагатай гадаад орчин нөхцөл бүрэлдэн тогтсон байна.

Төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед Монгол Улсын эдийн засгийн үндэс суурь болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт малчид мал аж ахуйн бүтээгдэхүүнийг төлөвлөгөөний дагуу улсад тушаадаг, улсын материал техникийн хангамжийн салбар шаардлагатай үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нийлүүлдэг систем тогтож байв. Энэхүү тогтолцоо нь Монголын зах зээлийн өсөлтийг хазаарлах хамгийн том саад тогтор болсон юм. Эдийн засгийн шилжилтийн дараа, хөдөө аж ахуйн хувьчлалыг дагалдан, хангамжийн тогтолцооноос борлуулалтын тогтолцоонд шилжиж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн бөөний худалдаа эрхэлдэг янз бүрийн хувьцаат компани, хувийн аж ахуй үүсэн байгуулагджээ. Түүнчлэн өргөн олон малчин бие даан үйлдвэрлэл эрхлэх эрхтэй болж, зах зээлийн хангамж хэрэглээний механизм, өрсөлдөөний механизм нь уламжлалт мал аж ахуйн

үйлдвэрлэлд нэвтэрч, мал аж ахуйн салбар зах зээлд шилжих үйл явцыг түргэтгэсэн байна.

Хөнгөн, хүнсний аж үйлдвэр, уул уурхай, худалдаа, тээвэр, холбооны зэрэг уламжлалт эдийн засгийн салбарын хувьчлал нь Монгол Улсын таваарын зах зээлийн хөгжлийг түргэтгэн, зах зээлийн систем бүрэлдэн тогтож, боловсронгуй болоход аятай нөхцлийг бүрэлдүүлэв.

Зах зээлийн системд хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хэрэгсэл зэрэг таваарын зах зээл багтах төдийгүй, хөрөнгийн, ажиллах хүчний, техникийн, мэдээллийн зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлийн зах зээл багтдаг. Түүний дотор таваарын зах зээл, хөрөнгийн зах зээл болон ажиллах хүчний зах зээл нь зах зээлийн системийн гурван том тулгуур болно.

Монгол Улс таваарын зах зээлийг түргэн хурдацтай хөгжүүлэхийн зэрэгцээ үнэт цаасны арилжаа буй болгох зэрэг замаар хөрөнгийн зах зээлийг нээж тодорхой амжилт олж байна. Гэвч ажиллах хүчний зах зээл харьцангуй сул байна. Тиймээс нэгдмэл цул, нээлттэй зах зээлийн системийг хэрхэн буй болгож, боловсронгуй болгох асуудал Монголын зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх чухал том зорилт болж байна.

### **3. Монголын онцлогтой зах зээлийн эдийн засгийн хөгжлийн загварыг шинжих нь**

Хөгжлийн загвар хэмээгч нь өвөрмөц онцлог бүхий хөгжлийн арга маяг, бодлого төлөвлөгөөний цогц нэгдэл юм.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн түүх хийгээд өнөө хэрэгжүүлж буй “гадагшаа хандсан” онцлог, олон улсын орчны хүчин зүйл, байгаль, газар зүйн нөхцөл, уламжлалт мал аж ахуйн эдийн засгийн үндэс зэрэг олон хүчин зүйл нь тус улсын эдийн засгийн шилжилт, хөгжлийн арга маяг, бодлого төлөвлөгөөний өвөрмөц онцлогийг тодорхойлж байна.

Монгол Улс эрс шинэтгэлийн загвараар “барууны маягийн ардчилсан тогтолцоо” болон зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шуудран “шилжсэн” нь үнэндээ хуучин ЗХУ, дорнод Европод гарсан өөрчлөлт зэрэг гадаад, дотоодын өвөрмөц нөхцөл байдлын үр дагавар байсан билээ.

Энэ асуудлыг Монголын эрдэмтэд судлаачид өөр өөрөөр тайлбарлаж, цөөн бус эрдэмтэн энэхүү загвар нь Монголын бодит байдалд нийцэхгүй байна гэж үзэж байна. Монголын засгийн газар үнэндээ энэхүү сохор таамгаар хийсэн сонголтыг ихээхэн хүнд ноцтой үнэ цэнээр хэрэгжүүлж буйг шилжилтийн эхэн үеийн практик нотолсон билээ. Энэ нь Монгол Улс тус улсын бодит байдалд “үл нийцэх” шинэчлэлийн загварыг сонгон авч, “Монголын онцлог бүхий” зах зээлийн эдийн засгийн тогтолцоо болон хөгжлийн загварыг боловсруулж хэрэгжүүлснийг харуулж байна. Тиймээс Монголын засгийн газар энэхүү өвөрмөц онцлог болон олон сөрөг хүчин зүйлийг сөрөн, тус улсын бодит

байдалд яв цав нийцсэн хөгжлийн загварыг боловсруулж хэрэгжүүлэх нь олон улсын чухал ач холбогдолтой юм.

Шилжилтийн орнууд шинэчлэлийг хоёр өөр загвараар хэрэгжүүлж байна. Тухайлбал, Хятад улсаар төлөөлүүлсэн аажим шинэчлэл, хуучин ЗХУ-аар төлөөлүүлсэн эрс шинэчлэлийн ашиг хор, амжилт бүтэлгүйтэл нь олон улсын эрдэмтдийн анхаарлыг татсаар байна. Эрс шинэчлэлийн загварын үзлийг баримтлагчдын шинжлэн дүгнэснээр, эрс шинэчлэлийн загварын эдийн засгийн үр ашиг нь хэдийгээр богино хугацаанд сөрөг нөлөө үзүүлэх боловч “үндсэн хуулийн засаглалын шилжилтийн” урт хугацааны эерэг үр нөлөө нь эдийн засгийн хөгжлийн явцын дунд илрэн гарах ажээ. Тэгэвч өнөөг хүртэл энэхүү дүн шинжилгээ нь зөвхөн Европ, Америкийн өндөр хөгжилтэй орнуудын туршлагын тухай ойлголтоор хязгаарлагдаж байна. Түүхэн хөгжлийн өөр өөр нөхцөл байдал бүхий бусад орнуудад энэ нь тохирох эсэх асуудлыг цаашид шинжлэн судлах шаардлагатай байна.

Монголын эрдэмтдийн харьцангуй санал нэгдэж буй үзэл баримтлал бол эдийн засгийн шилжилтийн явцад барууны орнуудын тэргүүний туршлагаас суралцах явдал зайлшгүй чухал, гэхдээ өөрийн орны бодит байдлыг үл харгалзан хүчээр хуулбарлаж үл болно хэмээн үзэж буй явдал юм.

Монгол Улс эрс маягийн шилжилтийн загварын учруулсан олон сөрөг нөлөөг амсч мэдэрсний дараа урьдын адил гаднын тусламжинд тулгуурлах, бусад орны туршлагыг хуулбарлан дуурайхын ноцтой хор холбогдлыг бүрнээ ухаарч, шинэчлэлийн бодлого болон хөгжлийн стратегийн зохицуулалтанд анхаарах болж, улмаар тус улсын бодит байдлыг олон улсын орчны хүчин зүйлтэй уялдуулан, ойрын болон дунд хугацааны хөгжлийн стратегийн зорилтыг боловсруулан хэрэгжүүлж байна. Тийнхүү бие дааж тусгаар тогтносон, өөрийн улсын баялгийн давуу тал болон олон улсын орчин нөхцөлд тулгуурлан эдийн засгаа цэцэглүүлэн хөгжүүлсэн, экологийн хүрээлэн байгаа орчинд нийцсэн, дэлхийн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд тогтвортой байр суурь эзэлсэн улс болохыг зорьж байна.

Монгол Улсын үе үеийн засгийн газар дээр өгүүлсэн стратегийн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө цуцалтгүй чармайлт тавьж, шинэчлэлийн алхмыг эрчимжүүлэх, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн системийг бүрдүүлэх зэрэг арга замаар “зах зээлийн эдийн засагт шилжихэд” чиглэсэн томоохон арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн, шинэчлэлийн эхэн үеийн эдийн засгийн ноцтой уналт, эрс маягийн шинэчлэлийн “муужруулах эмчилгээний” учруулсан янз бүрийн бэрхшээлийг аажмаар даван туулж, улс орны эдийн засагт сэргэлтийн шинжтэй өсөлт буй болж, макро эдийн засаг нааштай орчлын зүг эргэж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засгаа сэргээн тогтворжуулах талаар олсон ололт амжилтыг шинжвээс тус улсын эдийн засгийн хөгжлийн нөөц бололцоог олж харж болно. Гагцхүү бодлого нь үр нөлөөтэй, улс төр нь тогтвортой байваас Монгол Улс өөрийн баялгийн давуу тал, олон улсын орчин нөхцлийн ашигтай хүчин зүйлд тулгуурлан, Монголын онцлогтой зах зээлийн эдийн засгийн хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэн, өвөрмөц хөгжлийн загвараараа дэлхийн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд өөрийн “тогтвортой байр суурийг” эзэлж чадна.

Монголын шилжилтийн үеийн хөгжлийн стратеги, алхмыг шинжих замаар, Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн хөгжлийн загварын гол агуулгыг таньж болно. Энэ нь тус улсын онцлог байдал болон олон улсын орчны хүчин зүйлийг бүрэн харгалзан үзэж, эдийн засгийн бүтцийг аажмаар боловсронгуй болгон, гадаадад нээлттэй байдлыг өргөжүүлэн, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулан, гадаадын хөрөнгийг ихээр татах; өөрийн улсын баялгийн давуу талд түшиглэн, уул уурхайн аж үйлдвэр, мал аж ахуйн боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэн, үйлдвэржүүлэлтийн явцыг хурдасгах; тус улсын болон дэлхийн өндөр технологид суурилсан, экспортын шинжтэй зах зээлийн бүтцийг голлосон, экологийн орчинд тохирсон, бүтэц нь зөв оновчтой зах зээлийн системийг тогтоож, улмаар бүсчлэх, хотжуулах хөгжлөөр дамжуулан, уламжлалт мал аж ахуйг зах зээлд шилжүүлж, эрчимжүүлэх үйл явцыг түргэтгэн, Монголын онцлогтой зах зээлийн эдийн засгийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх явдал юм.

Эдүгээ цагийн дэлхий ертөнцийн эдийн засгийн даяаршлын үед Монгол Улс мөн адил “үсрэнгүй” хөгжлийн загварыг сонгон авч, гадаадын хөрөнгө болон өөрийн баялгийн давуу талаа ашиглан, мэдээллийн технологи болон мэдлэг төвлөрсөн үйлдвэрлэл, орчин үеийн тулгуур үйлдвэрлэлийг чухалчлан хөгжүүлж, мэдээллээр дамжуулан үйлдвэрлэлийн явцыг хөтлөх нь дамжиггүй. Эдийн засгийн шилжилтээс хойш Монголын дэд бүтэц, цахилгаан холбооны салбар түргэн хурдацтай хөгжиж байна. Дээр нь хүн амын соёлын түвшин нийтдээ харьцангуй өндөр зэрэг хүчин зүйлийг нэмвэл Монгол Улс орчин үеийн шинжлэх ухаан техникт түшиглэн, мэдээлэл зүйг хэрэгжүүлэх аятай нөхцөл бүрдээд байна. Монгол Улсын мал аж ахуйн үндэс суурь, байгалийн баялаг, экологийн хүрээлэн буй орчин зэрэг ашигтай нөхцлүүд нь тус улс уул уурхайн аж үйлдвэр, мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах аж үйлдвэрийн хөгжилд түшиглэн, үйлдвэржүүлэх үйл явцыг түргэтгэх, улмаар аялал жуулчлалын нөөц бололцоог нээж ашиглан, олон улсын хамтын ажиллагаанд оролцох явдалд тулгуурлан эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, Монголын онцлогтой зах зээлийн эдийн засгийн хөгжлийн загварыг хэрэгжүүлэх үндэс суурь мөн болно.